



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ - 2021



/АЛБАН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАВ/

HEALTH INDICATORS

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
2021

Гарчиг		
1	Эрүүл мэндийн зарим үзүүлэлтийг улсын дүнтэй харьцуулсан үзүүлэлт	3
2	Үйлчлэх хүрээний хүн ам зүйн байдал	4-5
3	Газар нутаг,хүн ам зүйн зарим бүтэц	6
4	Эх хүүхдийн эрүүл мэнд	7-9
5	Эх хүүхдийн эндэгдэл	10-11
6	Нас баралтын мэдээлэл	12
7	Жирэмсний хяналт	13
8	Үр хөндөлт	14
9	Жирэмслэлтээс сэргийлэх аргын хэрэглээ	15
10	Эхчүүдийн амрах байрны ашиглалт	16
11	Амбулаторийн тусламж үйлчилгээ	16
12	Хүн амын өвчлөл нас баралтын шалтгаан	17-18
13	Халдварт бус өвчний эрт илрүүлэг	19
14	Эмнэлгийн орны ашиглалт	20
15	Халдварт өвчин	20-22
16	Түргэн тусламжийн үйлчилгээ	23
17	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд	23
18	Ахмад настны эрүүл мэнд	24
19	Өрх, хүн амын эрүүл мэнд	25
20	Эм зүйн тусламж үйлчилгээ	26
21	Эмгэг судлалын үйл ажиллагаа	27
22	Сэтгэцийн эмгэгийн үеийн тусламж үйлчилгээ	27
23	Гемодиализийн тусламж үйлчилгээ	27
24	Хүний нөөцийн мэдээлэл	28-29
25	ЭМБ-н дэд бүтэц	30
26	ЭМБ-н мэдээллийн технологи тоног төхөөрөмж	31
27	ЭМҮ-ний чанарын мэдээлэл	32-35
28	БОЭТөвийн шатлалын тусламж үйлчилгээ	36
29	Эрүүл мэндийн санхүүжилт	36-39
30	Эм зүйн тусламж, хангамж хүртээмж	40

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙГ УЛСЫН ДҮНТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ

/2020.2021 оны жилийн эцсийн байдлаар/

Үзүүлэлт		Өмнөговь аймаг			Улсын дүн		
		2020 он	2021 он	Өсөлт бууралт	2020 он	2021 он	Өсөлт бууралт
Нийт үзлэг	Тоо	345268	331896	-13372	17540516	16651444	889072
Нэг иргэнд жилд үзүүлсэн тусламж	удаа	4.8	4.5	-0.3	5.3	4.9	-0.4
Урьдчилан сэргийлэх үзлэг	Нийт үзлэгт эзлэх хувь	33.1	41.3	8.2	28.5	30,5	2
Бүртгэгдсэн өвчлөл	тоо	80300	56649	-23651	2438343	2148716	-2254783
	10000 хүн амд	11231.8	7766.6	-3465.2	7395.9	6399.6	-996.3
Эхийн эндэгдэл	тоо	0	0	0	23	68	45
	100000 амьд төрөлтөд	0	0	0	30.2	94.9	64.7
Нялхсын эндэгдэл	тоо	20	18	-2	878	829	-49
	1000 амьд төрөлтөд	11.9	10.9	-1	11.5	11.6	0.1
Нярайн эндэгдэл	тоо	16	10	-6	596	591	-5
	Нялхсын эндэгдэлд эзлэх хувь	80	55.5	-24.5	67.9	71,2	3,3
0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	тоо	24	20	-4	1065	993	-72
	1000 амьд төрөлтөд	14.3	12.2	-2.1	14	13,9	-0,1
Халдварт өвчний гаралт	тоо	902	18046	17144	33376	575989	542613
	10000 хүн амд	130.4	2474.1	2343.7	101.2	1715,5	1614,3
Сүрьеэ	10000 хүн амд	3.8	2.1	-1.7	10.1	6,9	-3,2
БЗДХ	10000 хүн амд	55,2	30,3	-24,9	49,9	27,8	-22,1
Нийт төрөлт	Тоо	1677	1633	-44	75694	71166	-4526
	1000 хүн амд	24.2	22.3	-1.9	23,9		
Нас баралт	тоо	290	349	59	15924	19929	4007
	эмнэлэгт	65	88	23	4463	6941	2479
	Хоног болоогүй	33	29	-4	1086	1285	199
	Хорт хавдрын эзлэх хувь	24.8	21.2	-3.6			
	Осол гэмтлийн эзлэх хувь	12.7	14.6	1.9	17.1	15,2	-1,9
Хэвтэж эмчлүүлсэн хүн	тоо	15395	18402	3007	836272	930346	94069
	Ор хоног	97513	135455	37942	5805301	6991936	1186188
	Дундаж ор хоног	6.3	7.3	1	6.9	7,5	0,6
Жирэмсний эрт хяналт	хувь	90.2	90.6	0.4	89.9	90,6	0,7

Санхүүгийн үзүүлэлт	2020 он	2021 он	өөрчлөлт
Хөрөнгө оруулалт	5,795,9	4,495,5	-1,300,0
Улсын төсвийн санхүүжилт	17,939,066	19,865,360	1,925,294

ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭНИЙ ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

Өмнөговь аймаг 2021 оны эцэст урьдчилсан байдлаар 72935 хүн амтай болж, 2020 оны эцсийн хүн амаас 2.0 хувиар буюу 1442 хүнээр өссөн. Нийт хүн амын 50.1 хувь буюу 36542 эрэгтэйчүүд, 49.9 хувь буюу 36393 эмэгтэйчүүд эзлэж байна. Насны бүтцээр ангилвал 33.3 хувийг 0-14 насны хүүхэд, 60.0 хувийг 15-59 насны, 6.7 хувийг 60-с дээш насны хүн ам эзэлж байна. Нийт хүн амын 39.9 хувь Даланзадгад сумын төв, 30,1 хувь Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумдын төвд суурьшиж байна. Өрхийн тоо 23165 болж өмнөх оноос 1176 өрхөөр буюу 5.3 хувиар өссөн дүнтэй байна. Нэг өрхөд дунджаар 3,1 хүн ногдож байна. Нийт өрхийн 59.6 % нь суманд, 40.3 % нь аймгийн төвд байгаа нь өнгөрсөн оноос аймгийн төвийн өрхийн эзлэх хувь 1.2-р нэмэгдсэн байна. Нийт өрхийн 43.8 хувийг 1-2 ам бүлтэй өрх, 34.5 хувийг 3-4 ам бүлтэй өрх, 18.9 хувийг 5-6 ам бүлтэй өрх, 2.5 хувийг 7-дээш ам бүлтэй өрх эзэлж байна.

Хүн ам нийгмийн 2021 оны зарим үзүүлэлт


Өрх толгойлсон 2983 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 3 хувиар буурсан байна. Бүтэн өнчин хүүхэд 38 байгаа нь өмнөх оны мөн үеэс 8,5 хувиар өссөн, хагас өнчин хүүхэд 567 байгаа нь өмнөх оны мөн үеэс 5 хүүхдээр буюу 10,4 хувиар буурсан байна.

22 сургуулийн 513 бүлэгт өдрийн ангийн 14909 сурагчид хамрагдан суралцаж байна. 20 дотуур байранд 689 хүүхэд амьдарч байгаагаас 56,2% эмэгтэй хүүхэд байна. 719 багш ажиллаж байна.

Сургуулийн өмнөх боловсрол олгох цэцэрлэгт нийт 3617 хүүхэд хүмүүжиж байна. Политехникийн коллеж-д 835 суралцагсад суралцаж байна.

Аймгийн хэмжээнд 2021 оны мал тооллогын жилийн эцсийн дүнгээр 10243 малчин тоологдсон байна. Үүнээс 15-34 насны 2699 малчин буюу 26.3%, 35-59 насны 6176 буюу 60.3%, 60-аас дээш насны 1368 буюу 13.4% тус эзэлж байна. Нийт малчдын 43.7 хувь буюу 4473 эмэгтэй малчид байна.


Өмнөговь аймгийн хүн амын насны бүлэг, нас, хүйсийн суварга



Хүн амын нас, хүйсийн пирамид нь цаг хугацааны тодорхой үеийн хүн амын нөхөн үржихүйн тасралтгүй процессын явцыг харуулдаг бөгөөд төрөлт нас баралтын түвшин өндөр байвал пирамидын суурь өргөн орой руугаа нарийссан байх бөгөөд тухайн үзүүлэлт бага бол эсрэг дүрслэл харагддаг.

Сүүлийн жилүүдэд төрөлтийн түвшин өндөр байгаатай холбоотой Өмнөговь аймгийн хүн амын нас хүйсийн суваргын суурь нэлээд өргөсөж байгаа ба хүн амын ердийн хөдөлгөөний өөрчлөлтөөс шалтгаалан суваргын хэлбэр өөрчлөгдөж, хөдөлмөрийн насны буюу 20-34 насны хүн ам хүйсийн хувьд тэнцвэртэй өссөн нь харагдаж байна.

Хүн амын төрөлт, нас баралтын түвшин



Хүн амын ердийн хөдөлгөөн / сумдаар 2020.2021 оноор /

Сум, өрхийн нэр	Төрөлт 1000 хүн амд		Нас баралт 1000 х/а		Цэвэр өсөлт 1000х/ а	
	2020 он	2021 он	2020 он	2021 он	2020 он	2021 он
Баяндалай	15.8	11.4	6.7	7.1	9.0	4.3
Баян-овоо	18.2	16.9	3.7	7.7	14.8	9.3
Булган	18.5	13.3	5.9	3.8	12.3	9.5
Гурвантэс	18.3	19.3	4.1	5	14.1	14.2
Мандал-овоо	15.5	13.5	5.6	4.9	9.8	8.6
Манлай	19.7	19.7	2.7	4.9	16.9	17.2
Номгон	25.0	25	4.4	9.8	20.3	8.2
Ноён	19.3	19.3	4.3	6.3	14.8	9.9
Сэврэй	21.7	21.7	2.5	4.9	19.1	12.3
Ханбогд	18.7	18.7	1.4	2.2	18.5	19.3
Ханхонгор	15.1	15.1	6.5	2.5	8.5	12
Хүрмэн	19.9	15.1	4.5	4.4	15.1	10.7
Цогт-овоо	22.6	16.9	3.9	3.2	17.9	13.7
Цогтцэций	26.3	25.2	3.5	3.9	21.9	21.3
Шимбилэг	25.9	26.2	5.0	4.7	20.1	21.5
Өнө-орших	26.6	26.8	3.7	6.0	26.6	20.8
Энхийн хүслэн	26.8	24.6	4.6	5.2	22.2	19.4
Нийт	24.0	22.3	4,2	4,7	20	17,6

Хүн амын зарим бүтэц

Байгууллагын нэр	Үйлчлэх хүрээний хүн ам		Эрэгтэй / 2021/		0-5 хүртэлх насны хүүхэд/2021/		15-49 насны эмэгтэйчүүд		65-с дээш насны ахмад настан	
	2021	2022	тоо	хүн амд эзлэх хувь	тоо	хүн амд эзлэх хувь	тоо	хүн амд эзлэх хувь	тоо	хүн амд эзлэх хувь
Баяндалай	2113	2094	1103	52.7	195	9.3	503	24.0	192	9.2
Баян-овоо	1830	1831	928	50.7	226	12.3	459	25.1	146	8.0
Булган	2108	2095	1108	52.9	203	9.7	521	24.9	187	8.9
Гурвантэс	5194	5285	2655	50.2	608	11.5	1361	25.8	313	5.9
Мандал-овоо	1833	1631	845	51.8	181	11.1	399	24.5	133	8.2
Манлай	2667	2702	1385	51.3	374	13.8	655	24.2	205	7.6
Ноён	1419	1378	739	53.6	156	11.3	313	22.7	119	8.6
Номгон	2558	2494	1314	52.7	259	10.4	600	24.1	199	8.0
Сэврэй	2037	2035	1025	50.4	219	10.8	523	25.7	179	8.8
Ханбогд	8154	8079	4407	54.5	1020	12.6	1953	24.2	315	3.9
Ханхонгор	1992	2013	1079	53.6	180	8.9	462	23.0	204	10.1
Хүрмэн	1586	1572	805	51.2	167	10.6	378	24.0	131	8.3
Цогт-овоо	1896	1952	964	49.4	248	12.7	482	24.7	134	6.9
Цогтцэций	8439	8632	4343	50.3	1150	102.7	2218	25.7	298	3.5
Шимбилэг	11264	12060	5193	43.1	1448	12.0	2903	24.1	718	6.0
Өнө-орших	7306	7366	3456	46.9	915	12.4	2875	39.0	577	7.8
Энхийн хүслэн	9267	9720	4632	47.7	1266	13.0	2529	26.0	709	7.3
Нийт	71483	72939	36539	50.0	8865	12.2	19134	26.2	4893	6.7

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтрал, алслалт

д/д	Сумдын нэр	Эмнэлгүүдийн зэрэглэл	Нутаг дэвсгэрийн хэмжээ /мянган.км2/	Хүн амын нягтрал /1км2-д ногдох хүн/	Аймгийн төвөөс сум хүртэлх зай км	Багийн тоо
1	Даланзадгад		0.5	52.3	0	8
2	Баяндалай	Б	10.8	0.19	86	3
3	Баян-Овоо	Б	10.5	0.17	165	3
4	Булган	В	7.5	0.28	100	4
5	Гурвантэс	А	27.9	0.18	325	5
6	Мандал-Овоо	В	6.4	0.26	145	3
7	Манлай	Б	12.4	0.21	225	4
8	Номгон	Б	19.5	0.07	116	5
9	Ноён	Б	10.6	0.24	210	2
10	Сэврэй	Б	8.1	0.25	216	3
11	Ханбогд	А	15.2	0.50	270	5
12	Ханхонгор	В	9.9	0.20	25	4
13	Хүрмэн	Б	12.4	0.13	61	3
14	Цогт-Овоо	Б	6.5	0.28	120	3
15	Цогтцэций	А	7.2	1.09	100	4
	Аймгийн дүн		165.4	0.41	0	59

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

ТӨРӨЛТ

Аймгийн хэмжээнд 2021 онд 1633 эх төрж, 1639 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оноос төрөлт 2,6 %-р буюу 44 тохиолдлоор буурсан байна. Улсын хэмжээнд 71166 эх төрсөн нь өнгөрсөн оноос 6 хувиар буюу 4528 төрөлтөөр мөн буурсан байна. Өнгөрсөн онтой харьцуулахад Гурвантэс, Манлай, Ханбогд, суманд төрөлт нэмэгдсэн байна. Нийт төрөлтийн 24,3 % кесар хагалгаагаар, 0.6% нь амьгүй төрсөн нь эзэлж байгаа нь өнгөрсөн оноос нэмэгдсэн үзүүлэлтүүд байна. Нийт төрөлтийн 6 % нь охидын төрөлт, 0.3 % нь гэртээ төрсөн нь өмнөх жилийн үзүүлэлтийн түвшинд байна. Сумдын төрөх эхчүүдийн 65,6 %-ийг аймгийн төвд, БОЭТөвд шилжүүлэн төрүүлсэн нь өнгөрсөн онтой ижил үзүүлэлт байна. Нийт төрөлтийн 5,7 нь / 94/ дутуу төрсөн ба өнгөрсөн оноос 0,6-р нэмэгдсэн байна. / 2020-86/. Нийт төрсөн эхийн 91,7 % нь хяналтын үзлэгт 6 түүнээс дээш удаа хамрагдсан нь өнгөрсөн оноос 0,9-р буурсан байна. Нийт төрсөн эхчүүдийн, 21,6 % нь 1-2 жилийн зайтай төрсөн нь өнгөрсөн оноос нэмэгдсэн байна. Төрсөн эхчүүдийн 21,3 % нь 4 түүнээс дээш төрөлт, 3.7 % нь 40-с дээш насны ахимаг төрөлт байгаа байна. Нийт төрөлтийн 98,4% нь их эмчийн удирдлагын дор, 1,2 % нь эх баригч, 0,1% нь мэргэжлийн бус хүн эх барьсан төрөлт байна. Төрсөн эхчүүдийн 11,8 % төрөхийн, 14,6 % нь жирэмсний, 1,2 % нь төрсний дараа ямар нэгэн хүндрэлтэй байгаа нь өнгөрсөн оноос буурах хандлагатай байна.

Сумын нэр Sum	Нийт төрөлт		Аймагт төрөлт		Кесар хагалгаагаар төрсөн		Гэрт төрсөн		Амьгүй төрүүлсэн		Ихэр төрөлт		20-с доош насны төрөлт		20-с доош насны төрөлтийн хувь	
	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
Бд/Bd	33	24	29	17	3	3					1		1	1	3.0	4.2
Бo/Bo	34	31	29	25	9	10					1		2	4	5.9	12.9
БУ/Bu	38	28	31	23	8	4							4	2	10.5	7.1
Гт/Gt	94	100	72	78	13	24			1		1	1	8	2	8.5	2.0
Мо/Mo	25	22	23	21	5	4							1	2	4.0	9.1
Мн/Mn	52	59	46	56	8	15							9	6	17.3	10.2
Но/No	63	46	46	33	8	11	1					1	7	4	11.1	8.7
Нн/Nn	27	23	22	21	5	3		1				1	1	1	3.7	4.3
Сэ/Se	44	35	33	25	6	9					1	1	5	2	11.4	5.7
Хб/Khb	163	175	75	90	27	30	1	1	1	3		2	6	14	3.7	8.0
Хх/Khkh	30	29	29	27	5	6		1					3	2	10.0	6.9
Хү/Khu	31	24	30	23	5	5							2	1	6.5	4.2
Цо/Tso	41	32	30	25	10	10			1			1	4	2	9.8	6.3
Цц/Ts-ts	213	213	88	86	42	42	2		4	2	5	2	10	6	4.7	2.8
Бусад	34	72	34	72	11	26			1				3	7	8.8	9.7
Шб/Shb	281	296	281	296	82	84	1		1	2	2	5	14	13	5.0	4.4
Өо/Uo	225	196	225	196	64	57		1				1	13	13	5.8	6.6
Эх/Eh	249	228	249	228	52	54	1	1		4	1	2	13	16	5.2	7.0
Бүгд	1677	1633	1372	1342	363	397	6	5	9	11	12	17	106	98	6.3	6.0

ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

2021 онд нийт 1639 хүүхэд амьд төрсний 862 / 52.5 %/ нь хүү, 777 / 47,5%/ нь охин байгаа бол улсын хэмжээнд 71659 хүүхэд төрсний 36713 буюу 51.2 хувь нь хүү, 34946 буюу 48.8 хувь нь охин байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 105 хүү ногдож байна. Нийт төрсөн хүүхдүүдийн 3,5 % / 56/ нь 2500-с доош жинтэй төрсөн ба 97,8 % нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан байна. 21 хүүхэд төрөлхийн ямар нэг гажигтай төрсөн нь нийт хүүхдийн 1,2%-г эзэлж байгаа ба өнгөрсөн оноос 1,9-р нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энд зүрхний гажиг 1, уушигны 2, улаан хоолой ходоод гэдэсний 4, чихны дэлбэнгийн 1, эр бэлэг эрхтэний 2, гар хөл, тулгуур эрхтэний 7, уруул тагнайн сэтэрхий 4, тус тус бүртгэгдсэн ба эдгээрийн 2 нь амьдрах чадваргүй нас барсан. 0-1 насны хүүхдүүдийн 76.8%-г, 1-5 насны хүүхдүүдийн 41.1 %-г идэвхтэй хянасан нь 0-1 хүртэлх насанд нэмэгдэж, 1-5 насны хүүхдийн хяналт буурсан үзүүлэлт байна. 4 хүүхэд тураалтай байгаа нь нийт хүүхдийн 0,1 % -г эзэлж байна. Хүүхдийн хяналтын хувь харьцангуй бага буюу аймгийн дунджаас бага байгаа Булган, Гурвантэс, Мандал-Овоо, Номгон, Цогтцэций сумууд, ӨнөОрших, Энхийн хүслэн өрхийн ЭМТ анхаарал татаж байна. 0-1 насны хүүхдийн заавал хийх дархлаажуулалт 98,6 % тай хийгдсэн ба товлот дархлаажуулалтад 70 хүүхэд хоцорч хийгдсэн байна.

Сумын нэр	0-12 сартай хүүхэд /1нас/						12-59 сартай хүүхэд / 1-5 нас /						Нийт хүүхдийн хяналтын хувь
	Хүүхдийн тоо	идэвхтэй хянасан	Хяналтын хувь	Тураалтай	Туранхай	Тураалын хувь	Хүүхдийн тоо	идэвхтэй хянасан	Хяналтын хувь	Тураалтай	Туранхай	Тураалын хувь	
Бд	35	33	94.3				165	151	91.5				92.9
Бо	30	25	83.3				152	119	78.3		3		80.8
БУ	37	20	54.1				166	55	33.1		7		43.6
Гт	118	62	52.5				490	144	29.4				41.0
Мо	30	17	56.7				140	35	25.0				40.8
Мн	50	42	84.0				197	142	72.1				78.0
Но	63	41	65.1				206	107	51.9		6		58.5
Нн	30	30	100.0				126	126	100.0				100.0
Сэ	44	27	61.4				175	129	73.7		2		67.5
Хб	230	258	112.2				796	595	74.7		2		93.5
Хх	385	359	93.2				119	58	48.7		6		71.0
Хү	28	23	82.1				120	69	57.5				69.8
Цо	52	47	90.4				202	140	69.3	1		0.7	79.8
Цц	340	192	56.8	1		0.08	912	55	6.0	2	4	3.6	31.4
Шб	281	261	92.9				1179	587	49.8				71.3
Өо	197	106	53.8				694	66	9.5		2		31.7
Эх	235	134	57.0				1039	246	23.7		1		40.3
Бүгд	2185	1677	76.8	1		0.06	6878	2824	41.1	3	33	0.1	60


ХҮҮХДИЙН ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХАМРАЛТЫН МЭДЭЭ

№	Сумын нэр	БЦЖ		САА		САА /тарьдаг		ТАВТ		В гепатит		А гепатит		УГУ		ПЭВ		Нийт дүн	
		хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо
1	БД	100		100		100	0	100		100		87.5	2	94.7	1	100		97.7	3
2	БО	100		93.3	1	80	1	93.3	1	100		58.3	10	77.2	5	80	4	85.2	22
3	БУ	100		100		100		100		100		100		100		100		100	
4	ГТ	100		100		100		100		100		100		100		100		100	
5	МО	100		100		100		100		100		100		100		100		100	
6	МН	100		100		100		100		100		100		100		100		100	
7	НО	100		100		100		100		100		100		100		100		100	
8	НН	100		100		100		100		100		100		100		100		100	
9	СВ	100		100		100		100		100		100		100		100		100	
10	ХБ	100		93.7	3	100		100		100		100		96.9	3	95.8	6	98.3	12
11	ХХ	100		100		100		100		100		100		100		100		100	
12	ХҮ	100		91.6	1	100		91.6	1	100		95	1	100		100		97.2	3
13	ЦО	100		100		100		100		100		100		100		100		100	
14	ЦЦ	100		100		100		100		100		90.5	7	95.3	7	100		98.2	14
15	ШБ	100		99.2	2	97.2	2	99.2	2	100		100		100		100		99.4	6
16	ӨО	100		100		100		100		100		99.1	1	99.2	1	100		99.7	2
17	ЭХ	100		100		100		100		100		99.3	1	98.7	2	99.4	1	99.6	4
18	БОЭТ	98.8	4	100						100								99.6	4
19	ДҮН	99.9	4	98.8	7	98.7	3	99.1	4	100		95.9	22	97.8	19	98.5	11	98.6	70

ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ**ЭХИЙН ЭНДЭГДЭЛ**

Өмнөговь аймагт 2018,2019,2020,2021 онд эх эндээгүй. Эхийн ноцтой хүндрэлийн 5 тохиолдол гарч эхийн амь нас аврагдсан байна. Улсын хэмжээнд 68 эх эндсэн нь өнгөрсөн жилээс 40 тохиолдлоор нэмэгдсэн ба 100000 амьд төрөлтөд 94,9 болж 64,7-р нэмэгдсэн байна.Нийт эндэгдлийн 63,2 % /43/ нь Улаанбаатар хотод, 36,7 % /25 / аймгуудад эндсэн байна. Корона вирусын шалтгаанаар 46 эх эндсэн байна.

Эхийн эндэгдлийг улс аймгийн дүнтэй харьцуулбал:

**ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ**


2021 онд 0-1 насны 18 хүүхэд эндсэн нь 1000 амьд төрөлтөд өнгөрсөн оны мөн үеэс 2 тохиолдлоор буюу 0.9-р буурсан байна. Нялхсын эндэгдэлийн 72,2 % нь нярай үеийн нас баралт эзэлж байна. Нийт нялхсын эндэгдэлийн 44.4 % нь дутуу төрсөн ба амьсгал хямралын хам шинжээр 22.2%/4/ нь, Эх доторх халдварын шалтгаанаар 16.6 %/ 3/ нь осол гэмтлийн шалтгаант 11.1%/ 2/, хатгаагаар 22.2%/4/,төрөлхийн гажигаар 16,6% /3/ ишеми шалтгаан энцефалопати оношоор 5,5%/1/, суулгалтаар 5,5 % /1/ нярай эндсэн байна. 0-5 насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 2-р буурсан ба 65% нярай үеийн эмгэгээр, 20 % нь гажигаар, 20% нь хатгаа өвчнөөр нас барсан.

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 1,2 ногдож байгаа ба 2 эмэгтэй хүүхэд байна. 1-5 насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан нь гажиг, суулгалт байна.

Нийт 0-5 насны хүүхдийн эндэгдлийн 60% нь /12/ БОЭТөвд, 20% нь /4/ СЭМТ-д/ үлдэх 20% /4/ нь гэртээ, хээр гадаа эмнэлгийн тусламж аваагүй эндсэн байна.


Үзүүлэлт		Өмнөговь		өөрчлөлт	Улсын дүн		өөрчлөлт
		2020 он	2021 он		2020он	2021 он	
0-1 насны хүүхдийн эндэгдлийн тоо		20	18	-2	878	829	-49
үүнээс	1000 амьд төрөлтөд	11.9	10.9	-1	11.5	11,6	0,1
	Нярай үеийн эндэгдлийн эзлэх хувь	80	72.2	-7.8	67.9	71,3	3,4
	Үүнээс эрт нярай үеийн хувь	68.7	76.9	8.2	73.7	76,5	2,8
	Үүнээс хожуу нярай үеийн хувь	31.2	23	-8.2	26.3	23,5	-2,8
0-5 насны хүүхдийн эндэгдлийн тоо		24	20	-4	1065	993	-72
үүнээс	1000 амьд төрөлтөд	14.2	12.2	-2	14	13,9	-0,1

Нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд




/Өмнөговь сумдаар 2021 он/

Улсын дүн / аймгуудаар/



5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд / 2021 оны эцэс аймгаар /




Хүүхдийн эндэгдлийн байдлыг 2 оноор харьцуулбал:

Сумын нэрSum	0-1 насны эндэгдэл		0-1 насны эндэгдэл /1000 амьд төрөлтөд		1-5 насны эндэгдэл		1-5 насны эндэгдэл /1000 амьд төрөлтөд		Эрт нярай үеийн нас баралтын тоо		Нялхасын эндэгдэлд эрт нярай үеийн нас баралтын хувь	
	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
Баяндалай												
Баян-овоо		1		32.3								
Булган		1		35.7	1		26.3			1		100
Гурвантэс	3/1/БООТ	2/1/БООТ	31.9	19.8					2/1/БООТ		66.6	
Мандал-овоо	1	2/1/БООТ	40	90.9	1		40			2/1/БООТ		100
Манлай	1		19.2						1		100	
Номгон	1/БООТ	2/1/БООТ	15.9	42.6					1/БООТ	1/БООТ	100	50
Ноён												
Сэврэй	1/БООТ		22.7						1/БООТ		100	
Ханбогд	1	1	6.1	5.8		1		5.8		1		100
Ханхонгор	1/БООТ		33.3						1/БООТ		100	
Хүрмэн	1		32.3			1/БООТ		41.6				
Цогт-овоо												
Цогтцэций	3/2/БООТ	1	14.1	4.7					2/1/БООТ		66.6	
Бусад	1	2								1		50
Шимбилэг	2/БООТ	2/БООТ	7.1	6.7	1/БООТ		3.5		1/БООТ	2/БООТ	50	100
Өнө-орших	3/БООТ	2/БООТ	13.3	10.2					2/БООТ		66.6	
Энхийн хүслэн	1/БООТ	2/БООТ	4	8.8	1/БООТ		4			2/БООТ		100
Өмнөговь	20	18	11.9	11	4	2	2.3	1.2	11	10	55	55.5
Улсын дүн	878	829	11.5	11.6	187	164	2.4	2.3	439	452	73.7	76.5


НАС БАРАЛТ 2021 оны жилийн эцсийн байдлаар нас баралтын 349 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 59 тохиолдлоор нэмэгдсэн ба нийт нас баралтын 25,2 % нь эмнэлэгт, үүний 32,9 % нь хоног болоогүй нас барсан байна. Нийт нас баралтын 57,3 % нь /200/ эрэгтэй, 42,7% нь /149/ эмэгтэй байна. Нийт нас баралтад сэргийлж болох нас баралтаас хорт хавдар 21,2 %-г , осол гэмтэл 14,6%, зүрхний шигдээс болон хомсдох өвчин 14,3%, тархинд цус харвалт 5,7 % байна. Осол гэмтлийн нас баралтын 51 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 6,9 байгаа ба улсын дүнгээс 2,5-р /9,4 / бага байна. Нас баралтын 45.2 % нь 60-с доош насны харьцангуй залуу хүмүүсийн эндэгдэл эзэлж байна.

Сум өрхийн нэр	Нийт нас баралтTotal death rate		Эмнэлэгт нас баралтDeath in hospital		Хоног болоогүй Before 24 hours death		Осол гэмтлийн нас баралтInjury, poisoning and certain other consequences		Хорт хавдрын нас баралтNeoplasms		Зүрхний ишемит болон шигдээсний шалтгаант нас баралт		Тархинд цус харвалтаар нас баралт	
	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
Бд	14	15	3	4		1	1	2	5	2		1	1	
Бо	7	14	2	4	2	1	3	2		3	1	1	2	2
БУ	12	8	1	2			3		2	3		1	2	
Гт	21	26	7	5	4	2	5	4	1	2		4	1	1
Мо	9	8	1	3				1	3	1		2	1	1
Мн	9	13	3	2	2		2	4	1	1		3		
Но	9	25	2	6	2			3	1	2	2	8		1
Нн	6	9	1	4	1	1	1	2	2	1				1
Сэ	5	10	1	2	1			1	1	2	1	2		
Хб	12	18	1	5		2	1	2	5	3	1	1		1
Хх	13	5	3		1			1	2	1	1	1	3	1
Хү	7	7	1	3	1	1	1	2	2	1	1			
Цо	7	6	2				1	3	3	2				
Цц	7	33	7	10	5	4		6		3	1	3	2	4
бусад	3	7	3	7	1	5	2	7		2	1		2	3
Шб	54	53	12	13	2	5	7	4	16	17	6	8	1	2
Өо	31	44	5	10	5	4	3	4	10	12	2	10	3	1
Эх	43	48	10	8	6	3	4	3	13	16	6	5	5	2
Нийт	290	349	65	88	33	29	37	51	72	74	23	50	25	20
Хувь			22.4	25.2	11.4	8.3	12.8	14.6	24.8	21.2	7.9	14.3	8.6	5.7

Нас баралтын шалтгаан




Нас баралт, насны ангилалаар



ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТ

2021 онд 1730 эмэгтэй шинээр жирэмсний хяналтад орсны 90,6% эрт, 0,8% хожуу хяналтад орсон байна. Нийт хяналтад орсон жирэмсэн эхчүүдийн 4,9% нь 20-с доош насны охидын жирэмслэлт эзэлж байна. Төрсөн бүх эхчүүдийг жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш хяналтад хамруулсан хувь 91,7% байна. Нийт жирэмсэн эхчүүдийн 99,7%-г цусны шинжилгээнд хамруулсан ба 1,5% нь цус багадалттай, 1,2% нь бэлгийн замаар дамжих халдвартай байсан байна.

Сумын төв	оны эцэст жирэмсний хяналтад байгаа эмэгтэй No of pregnant women	Шинээр хяналтад орсон No of women ANC new visits	Үүнээс/ out of them				Шинээр хяналтад орсон жирэмснээс цусны шинжилгээ өгсөн /Blood test coverage of ANC controlling	Цус багадалттай жирэмсэн Анаemia of pregnant woman	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш үзүүлсэн хувь
			Эхний 3 сартай/ANC visits during first trimester	4-6 сартай 4-6 Month	7 дээш сартай/During 7 month or later	20-с доош насны жирэмслэлт No of pregnancies under 20 y/a			
Бд/Bd	15	31	28	3			31	2	74.2
Бо/Bo	8	20	20			2	20		140.0
БУ/Bu	14	21	17	4		1	21		100.0
Гт/Gt	55	138	130	8		5	138	10	68.1
Мо/Mo	18	39	39			2	39		53.8
Мн/Mn	12	46	42	4		6	46		121.7
Но/No	22	48	48			2	44		81.3
Нн/Nn	13	33	32	1			33		78.8
Сэ/Se	12	38	37	1		1	38		86.8
Хб/Khb	98	193	182	10	1	10	193		79.8
Хх/Kh-kh	9	24	22	2		1	23		120.8
Хү/Khu	3	18	16	2			18		133.3
Цо/Tso	13	29	24	4	1	3	29	5	89.7
Цц/Ts-ts	121	286	237	41	8	15	286		67.8
Шб/Shb	103	330	286	44		9	330		83.6
Өо/Uo	105	160	154	5	1	15	160	1	113.8
Эх/Ekh	110	276	254	19	3	11	276	8	75.4
Бүгд Total	797	1730	1568	148	14	83	1725	26	82.9
Хувь			90.6	8.5	0.8	4.7	99.7	1.5	



ҮР ХӨНДӨЛТ


Аймгийн хэмжээнд 2021 онд нийт 567 эмэгтэй үр хөндүүлсэн нь өнгөрсөн оноос 157 тохиолдлоор буурсан ба 1000 амьд төрөлтөд 345,9 ногдож байна. Нийт үр хөндөлтийн 30,6% нь БОЭТөвд, 69,4% нь хувийн эмнэлэгт тохиолдсон байна. Нийт үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 9,5 % нь 20-с доош насны оюутан, 15,8% нь ажилгүй, 10,7 % нь малчин, 64% нь ажил эрхэлдэг эмэгтэйчүүд байна. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 71,7 % нь анх удаа, 18,3 % нь 2 удаа, 9,7% нь 3 удаа, 0,1 % 4-5 удаа үр хөндүүлсэн байна. Мөн төрөөгүй эмэгтэй 15,8% /90/ байгаа нь өнгөрсөн оноос нэмэгдсэн байна. 11 эмэгтэй хожуу үр хөндүүлжээ.

Сумын нэр	Нийт үр хөндөлт		Үүнээс хожуу үр хөндөлт		19-с доош насны үр хөндөлт		1000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлт	
	Total abortion		Late abortion		No of abortions conducted in women under 19 age		Early abortion per 1000 live births	
	2020 он	2021 он	2020 он	2021 он	2020 он	2021 он	2020 он	2021 он
Бд/Bd	15	12				4	441.2	500.0
Бо/Bo	9	9			1	1	264.7	290.3
БУ/Bu	14	21		1	3	3	368.4	750.0
Гт/Gt	47	38	1	2	4	5	500.0	376.2
Мо/Мо	10	4			3		400.0	181.8
Мн/Mn	6	12			1	3	115.4	203.4
Но/No	17	14			1	1	269.8	297.9
Нн/Nn	12	11	1		3	1	444.4	458.3
Сэ/Se	17	5			2	1	377.8	138.9
Хб/Khb	43	28		1	3	1	265.4	161.8
Хх/Kh-kh	21	15	2	1		1	700.0	517.2
Хү/Khu	8	7		1	1		258.1	291.7
Цо/Tso	18	12			3	2	450.0	363.6
Цц/Ts-ts	60	39	1		2	3	280.4	182.2
Шб/Shb	157	107	2	1	10	6	556.7	357.9
Өо/Uo	89	77		3	6	10	395.6	392.9
Эх/Ekh	155	93			7	6	620.0	409.7
Бусад газар	26	63	2	1	3	6		
Бүгд Total	724	567	9	11	52	54	431.0	345.9
хувь			1.2	1.9	7.1	9.5		


ЖИРЭМСНЭЭС СЭРГИЙЛЭХ АРГЫН ХЭРЭГЛЭЭ

Сумын нэр Sum	Бүгд Contraceptive methods total	Үүнээс /Out of them							Төрөх насны эмэгтэйчүүдийн дунд ЖСА хэрэглээн ий хувь
		Эм Pills	Тариа Injec tables	Норплан д Norplant	Бэлгэвч Condoms	Ерөндөг/UDs	Стерелизаци Sterilization	Бусад	
Бд/Bd	269	63	35	52	51	42	26		53.5
Бо/Bo	186	62	41	18	18	32	15		40.5
Бу/Bu	329	149	52	15	57	42	10	4	63.1
Гт/Gt	839	168	115	55	361	108	32		61.6
Мо/Mo	243	39	28	19	23	80	49	5	60.9
Мн/Mn	405	73	18	12	73	184	28	17	61.8
Но/No	412	87	38	36	52	140	25	34	68.7
Нн/Nn	137	39	16		29	39	2	12	43.8
Сэ/Se	292	48	50	59	14	110	11		55.8
Хб/Khb	1407	372	83	98	403	313	56	82	72.0
Хх/Kh-kh	234	49	23	10	74	62	16		50.6
Хү/Khu	243	58	22	20	58	68	17		64.3
Цо/Ts-o	376	89	62	10	95	91	24	5	78.0
Цц/Tsts	1030	373	112	125	145	275			46.4
Шб/Shb	1188	228	76	151	180	403	102	48	40.9
Өо/Uo	1115	373	177	67	299	130	69		38.8
Эх/Ekh	1241	285	128	122	334	298	74		49.1
Бүгд/Total	6402	1669	695	529	1453	1586	311	159	51.9
Эзлэх хувь		26	10.8	8.2	22.6	24.7	4.8	2.4	

ЖСА хэрэглээний хувь / сум өрхөөр/:



ЖСА хэрэглээний бүтэц:




ЭХЧҮҮДИЙН АМРАХ БАЙРНЫ АШИГЛАЛТ

2020 онд 15 эхчүүдийн амрах байранд нийт 174 эх 1322 ор хоногоор амарсан ба амарвал зохих эхийг 97,2 хувь амраасан байна. Цогтцэций сумын эхчүүдийн амрах байраар эхчүүд амраагүй байна.

Байршил	Амрах байрны тоо		Байрандаа засвар хийсэн	Тохижилт хийсэн	Орны тоо	Ашигласан ор хоног	Амарвал зохих эхийн тоо	
	Зориулалтын байр	Эмнэлэг					Бүгд	Үүнээс: Амарсан
Ноён	1			1	2	9	3	3
Ханбогд		1			2	203	36	36
Цогтцэций								
Сум дундын эмнэлэг	1	1		1	4	212	39	39
Баяндалай	1			1	2	31	4	4
БаянОвоо	1			1	2	15	3	3
Булган	1				1			
Гурвантэс		1			1			
МандалОвоо		1			2			
Манлай		1			2			
Номгон		1			2	25	5	5
Сэврэй								
Ханхонгор		1			2	55	17	7
Хүрмэн		1			1			
ЦогтОвоо		1			1	3	1	1
Сумын эрүүл мэндийн төв	3	7		2	16	129	30	20
БОЭТөв	1				10	391	47	47
Нийт	5	8		3	30	732	116	106

АМБУЛАТОРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ


Аймгийн хэмжээнд нийт 331896 үзлэг хийгдсэн нь өнгөрсөн оноос 13372 үзлэгээр буурсан байна. Нийт үзлэгт хамрагсдын 41,9% нь эрэгтэй, 58,1% нь эмэгтэй, 24,1% нь 0-18 насны хүүхэд, 15,8% нь 55-с дээш насны ахмадууд үйлчлүүлсэн байна. Амбулаторийн нэг эмчид дунджаар 3771 үзлэг ногдож байна. Нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь 41.3 болж өнгөрсөн оноос 7.2-р нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн өвчлөлд осол гэмтлийн өвчлөл 2,1% -г /1236/ эзэлж байгаа нь өнгөрсөн оноос 0.4%-р нэмэгджээ.

Амбулаторийн үзлэгийн төрлийг хувиар / 2020, 2021 оноор/

ЭМНЭЛГҮҮДИЙН НИЙТ ҮЗЛЭГ, БҮРТГЭГДСЭН ӨВЧЛӨЛ

Сумын нэр/Sum	Нийт үзлэг/Total examination		Урьдчилан сэргийлэх үзлэг/Prophylactic examination		Нэг иргэнийг үзсэн удаа/Average visits per person per year		Бүртгэгдсэн өвчлөл/Outpatient morbidity		Бүртгэгдсэн өвчлөл 10000 х/а/Outpatient morbidity / per 10000 pop /	
	2020	2021	2020	2021	2019	2020	2020	2021	2020	2021
Бд	7872	8826	2566	3093	3.7	4.2	992	989	4694.7	4723.0
Бо	3950	4961	1849	3619	2.2	2.7	841	627	4595.6	3424.4
Бу	2705	2794	776	1230	1.3	1.3	239	188	1133.8	897.4
Гт	15195	12168	8524	6884	2.9	2.3	4426	3320	8521.4	6281.9
Мо	6087	3690	1994	930	3.3	2.3	202	166	1102.0	1017.8
Мн	8537	6938	4419	3039	3.2	2.6	1993	1801	7472.8	6665.4
Но	4903	7177	1758	4887	3.5	5.2	959	492	6758.3	3570.4
Нн	13645	11474	8347	6457	5.3	4.6	948	675	3706.0	2706.5
Сэ	5054	4853	1775	2358	2.5	2.4	966	468	4742.3	2299.8
Хб	20839	16968	4733	5209	2.6	2.1	4369	4457	5358.1	5516.8
Хх	7738	10056	5301	7433	3.9	5.0	202	226	1014.1	1122.7
Хү	5643	5784	2043	2547	3.6	3.7	512	247	3228.2	1571.2
Цо	5773	8833	2279	4769	3.0	4.5	642	494	3386.1	2530.7
Цц	14078	16873	1744	1480	1.7	2.0	5600	5033	6635.9	5830.6
БООЭТөв	110182	67171	38734	24162			35541	20593		
Шб	24886	34483	6164	14721	2.2	2.9	4213	1619	3740.2	1342.5
Өо	15498	27775	3620	14524	2.1	3.8	2808	2671	3843.4	3626.1
Эх	22947	33812	7769	17562	2.5	3.5	2993	1991	3229.7	2048.4
Хувийн хэвшил	38225	39058	4088	4956			10394	10334		
Цэргийн анги	5156	8202	4696	7315			389	258		
Дүн	345268	331896	114320	137145	4.8	4.6	80300	56649	11233.4	7766.6


ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН / СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР /



ХҮН АМЫН ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТЫН ШАЛТГААН / өвчний ангиллаар /

№	Өвчний бүлэг	Бүртгэгдсэн өвчлөл				Нас баралт			
		Тоо		10000 хүн амд		Тоо		10000 хүн амд	
		2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
1	Хоол шингээх эрхтний өвчин	23152	16416	3238.8	2250.6	30	34	4.2	4.7
2	Амьсгалын тогтолцооны өвчнүүд	16628	10075	2326.1	1381.3	11	29	1.5	4.0
3	Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	8833	6035	1235.7	827.4	9	9	1.3	1.2
4	Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	7754	7233	1084.7	991.7	106	131	14.8	18.0
5	Бэртэл хордлого гаднын шалтгаант өвчин	1442	1236	201.7	169.5	37	51	5.2	7.0
6	Чих ба хөхөнцрийн өвчин	2225	1483	311.3	203.3				
7	Халдварт өвчин	902	18046	126.2	2564.3				
8	Нүд ба түүний дайврын өвчнүүд	2319	1521	324.4	208.5				
9	Арьс халимны өвчнүүд	3667	2682	513.0	367.7				
10	Мэдрэлийн тогтолцооны өвчин	6465	5237	904.4	718.0	4	6	0.6	0.8
11	Яс булчин холбох нэхдэсний өвчин	3980	2881	556.8	395.0	2		0.3	
12	Дотоод шүүрэл тэжээл бодисын солилцоо	2028	1591	283.7	218.1	4	2	0.6	0.3
13	Цус цус бүтээх эрхтний өвчин	313	469	43.8	64.3		1		0.1
14	Хавдар	50	45	7.0	6.2	72	74	10.1	10.1
15	Сэтгэцийн эмгэг	730	358	102.1	49.1				
16	Төрөлхийн гажиг, өнгөт тогтолцооны гажуудал	93	78	13.0	10.7		3		0.4
17	Жирэмсэн төрөх, төрсний дараах үе	309	379	43.2	52.0				
18	Төрөх тойрны перинаталь үед үүсэх эмгэг	140	149	19.6	20.4	15	9	2.1	1.3
19	Бүгд	80300	56649	11233.4	7766.6	290	349	40.6	47.8

ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН / СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР /



ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ

Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг 45,22% тай хийгдсэн нь өнгөрсөн оноос 22,4-р нэмэгдсэн ба Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумд, Шимбилэг өрхийн эмнэлгүүдийн хамралт аймгийн дунджаас доогуур байна. Артерийн гипертензи эрт илрүүлэг 48,5, чихрийн шижин өвчний үзлэг 49,3, умайн хүзүүнийх 36,6, хөхний өмөн илрүүлэх үзлэг 50,7, элэгний эрт илрүүлэг 41% тай тус тус хийгдсэн. Эрт илрүүлэгт хамрагсдын 45,9 % нь эрэгтэй, 54,1 % нь эмэгтэйчүүд байна. Эрт илрүүлэг үзлэгийн үр дүнд артерийн гипертензи өвчтэй 129, чихрийн шижинтэй 12, хөхний өөрчлөлттэй 117, умайн хүзүүний өөрчлөлттэй 718 хүнийг илрүүлж, 686 сорьцыг шинжилж 125 хавдрыг эд эсийн шинжилгээгээр баталгаажуулан эрт үед нь эмчилгээнд хамруулсан байна. Үүнээс эрт үедээ 16 хавдар оношлогдсон. Мөн В вирустэй 112, С вирустэй 82 хүнийг нарийн мэргэжлийн эмчийн эмчилгээ, хяналтад авсан байна. 2021 оны эцсийн байдлаар артерийн даралт ихсэх өвчний улмаас 1286, чихрийн шижингийн улмаас 210 хүн тус тус хяналтад эмчлэгдэж байна.

Эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтыг сумдаар:

		Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг			Чихрийн шижингийн эрт илрүүлэг			Элэгний хавдарын эрт илрүүлэг/15-65/			Умайн хүзүүний эсийн шинжилгээ			Хөхний үзлэгт хамрагдсан хүн			Дундаж хувь
Эмнэлг ийн нэр		хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь	
1	Бд	1027	873	85.0	1155	958	82.9	288	99	34.4	138	60	43.5	452	337	74.6	64.1
2	Бо	711	711	100	770	770	100.0	785	781	99.5	82	60	73.2	301	254	84.4	91.4
3	Бу	405	275	67.9	405	275	67.9	416	370	88.9	98	8	8.2	391	48	12.3	49.0
4	Гт	1383	436	31.5	1792	435	24.3	3408	366	10.7	252	149	59.1	1238	574	46.4	34.4
5	Мо	900	737	81.9	900	624	69.3	936	583	62.3	97	28	28.9	377	252	66.8	61.8
6	Мн	1205	1247	103	985	1363	138.4	1538	1413	91.9	152	133	87.5	592	498	84.1	101.1
7	Нн	987	405	41.0	987	405	41.0	987	405	41.0	101	62	61.4	422	176	41.7	45.2
8	Но	395	391	99.0	395	391	99.0	987	1000	101.3	103	69	67.0	375	268	71.5	87.5
9	Сэ	1140	916	80.4	1024	1019	99.5	1090	28	2.6	127	95	74.8	460	447	97.2	70.9
10	Хб	5312	0	0.0	5312	0	0.0	5312	265	5.0	355	61	17.2	1889	374	19.8	8.4
11	Хх	352	431	122	352	431	122.4	430	94	21.9	132	62	47.0	385	220	57.1	74.2
12	Хү	364	516	141	426	522	122.5	989	882	89.2	90	61	67.8	370	277	74.9	99.2
13	Цо	375	380	101	375	380	101.3	958	620	64.7	112	55	49.1	489	331	67.7	76.8
14	Цц	3500	0	0.0	3500	0	0.0	3500	555	15.9	400	36	9.0	2000	47	2.4	9.1
Сумын дүн		18056	7318	40.5	18378	7573	41.2	21624	7461	34.5	2239	939	41.9	9741	4103	42.1	40.1
15	Шб	4389	1286	29.3	4389	1286	29.3	2200	1135	51.6	623	225	36.1	2250	1194	53.1	39.9
16	Өо	1344	672	50.0	1344	672	50.0	1115	852	76.4	462	122	26.4	1342	1118	83.3	57.2
17	Эх	5132	4744	92.4	5246	4734	90.2	1903	1563	82.1	483	100	20.7	2218	1472	66.4	70.4
Өрхийн дүн		10865	6702	61.7	10979	6692	61.0	5218	3550	68.0	1568	447	28.5	5810	3784	65.1	56.9
Нийт дүн		28921	14020	48.5	28962	14265	49.3	26842	11011	41.0	3787	1386	36.6	15551	7887	50.7	45.2

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ


2021 онд хэвтүүлэн эмчлэх улсын төсвийн 15, хувийн 6 эмнэлэгт 18532 хүн 135455 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 3137 тохиолдлоор нэмэгдсэн ба эмчлүүлэгсдийн дундаж ор хоног/ 7,4 /, орны фонд ашиглалт/ 194,6/ орны эргэлт / 26,4/ тус тус нэмэгдсэн байна. Мэс засалд 1948 хүн орсны 9 % буюу 176 хүүхэд байна. Үүнээс дурангийн хагалгаа 77 хийгдсэн нь өмнөх оноос буурсан байна. Мэс заслын хүндрэл 6 тохиолдож нас баралт гараагүй байна. Улсын хэмжээнд 930346 хүн 6991936 ор хоногоор хэвтэн эмчлүүлсний дундаж ор хоног 7,5 байгаа нь мөн нэмэгдсэн үзүүлэлт байна.

Эмнэлгийн орны ашиглалт / байгууллагуудаар /

Сумын нэр Sum	Орны тоо Hospital beds	Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүн Number of inpatients		Ор хоног Bed days		Дундаж ор хоног Average length of stay		Орны эргэлт Number of patients per bed per year		Орны фонд ашиглалт Utilization of bed fund	
		2020 он	2021 он	2020 он	2021 он	2020 он	2021 он	2020 он	2021 он	2020 он	2021 он
БД/Bd	11	135	386	1007	3513	7.5	9.1	12.3	35.1	91.5	319.4
БО/Bo	10	219	297	1576	2315	7.2	7.8	21.9	29.7	157.6	231.5
БУ/Bu	10	137	300	838	2682	6.1	8.9	13.7	30.0	83.8	268.2
ГТ/Gt	17	412	417	2342	3131	5.7	7.5	24.2	24.5	137.8	184.2
МО/Mo	10	271	362	1511	2856	5.6	7.9	27.1	36.2	151.1	285.6
МН/Mn	12	203	386	1360	3564	6.7	9.2	16.9	32.2	113.3	297.0
НО/No	12	150	150	878	973	5.9	6.5	12.5	12.5	73.2	81.1
НН/Nn	11	310	500	2308	4173	7.4	8.3	28.2	45.5	209.8	379.4
СЭ/Se	12	173	224	1029	1672	5.9	7.5	14.4	18.7	85.8	139.3
ХБ/Khb	35	941	1203	5912	8209	6.3	6.8	26.9	34.4	168.9	234.5
ХХ/Kh-kh	7	150	373	1245	3426	8.3	9.2	21.4	53.3	177.9	489.4
ХҮ/Khu	10	148	165	1118	1447	7.6	8.8	14.8	16.5	111.8	144.7
ЦО/Tso	11	300	377	1509	2923	5.0	7.8	27.3	34.3	137.2	265.7
ЦЦ/Ts-ts	45	1173	1451	6803	9662	5.8	6.7	26.1	32.2	151.2	214.7
БОЭТөв	349	7381	8549	48247	62870	6.5	7.4	21.1	24.5	138.2	180.1
Хувийн эмнэлэг	114	3255	3228	21608	21782	6.6	6.7	28.6	28.3	189.5	191.1
Цэргийн анги 166	20	37	34	222	257	6.0	7.6	1.9	1.7	11.1	12.9
Дүн Total	696	15395	18402	97513	135455	6.3	7.4	22.1	26.4	140.1	194.6

ХАЛДВАРТ ӨВЧИН 2021 онд 18046 халдварт өвчин бүртгэгдсэн нь 10000 хүн амд 2564,3 болж өнгөрсөн оноос 2347,8-р нэмэгдсэн ба Ковид-19 өвчлөл шинээр бүртгэгдэж нийт халдварын 98% эзэлж байна. БЗДХ, гар хөл амны өвчин, салхин цэцэг, хачигт рекисиоз зэрэг өвчлөл бүртгэгдсэнч өмнөх оноос буурсан байна. Халдварт өвчний гаралт аймгуудын дунджаас 765-р / 1799,3/ их, улсын дунджаас 848,8 / 1715,5/ тус тус өндөр байгаа ба улсын хэмжээнд халдварт өвчин нэмэгдсэн байна.


Халдварт өвчний гаралтыг улс аймгийн түвшинтэй харьцуулбал /10000 хүн амд /:



Нийт халдварт өвчин болон БЗДХалдвар /сум өрхөөр/:

Сумын нэр Sum	Нийт халдварт өвчин /Total/								Бэлгийн замаар дамжих халдвар							
					Тэмбүү /Syphilis/				Заг хүйтэн/Gono-coccai infection/				Трихомониаз /Trichomoniasis/			
	Бодит тоо abs.num		10000 хүн амд per10000pop		Бодит тоо abs.num		10000 хүн амд per10000pop		Бодит тоо abs.num		10000 хүн амд per10000pop		Бодит тоо abs.num		10000 хүн амд per10000pop	
	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
БД/Bd	32	323	151.4	1542.5	2	1	9.5	4.8	4		18.9		5		23.7	
БО/Bo	15	272	82.0	1485.5	1		5.5	0.0					3		16.4	
БУ/Bu	7	360	33.2	1718.4	2		9.5	0.0	1		4.7		1	1	4.7	4.8
ГТ/Gt	18	563	34.7	1065.3	1		1.9	0.0	1		1.9		5	1	9.6	1.9
МО/Mo	11	187	60.0	1146.5	4	1	21.8	6.1	1	1	5.5	53.5	3		16.4	
МН/Mn	94	647	352.5	2394.5	8	1	30.0	3.7	5		18.7		3		11.2	
НО/No	31	339	218.5	2460.1	1	1	7.0	7.3	4		28.2		7	1	49.3	7.3
НН/Nn	21	252	82.1	1010.4	1		3.9	0.0	2		7.8		9		35.2	
СЭ/Se	34	180	166.9	884.5	4		19.6	0.0	5		24.5		4	2	19.6	9.8
ХБ/Khb	42	1658	51.5	2052.2	5	3	6.1	3.7	5	1	6.1	6.0	10	2	12.3	2.5
ХХ/Kh-kh	20	269	100.4	1336.3	2		10.0	0.0	1	1	5.0	37.2	4	1	20.1	5.0
ХҮKhu	44	255	277.4	1622.1	3		18.9	0.0	3	3	18.9	117.6	4	1	25.2	6.4
ЦОТso	29	409	153.0	2095.3	4		21.1	0.0	3	1	15.8	24.4	5		26.4	
ЦЦ/Ts-ts	40	1987	47.4	2301.9	5	2	5.9	2.3	1		1.2		2	1	2.4	1.2
бусад	51	3332			43	7			3	2			2			
ШБ/Shb	135	2960	119.9	2454.4	16	14	14.2	11.6	14	3	12.4	10.1	20	6	17.8	5.0
ӨО/Uo	132	1608	180.7	2183.0	19	15	26.0	20.4	22	8	30.1	49.8	41	5	56.1	6.8
ЭХ/Ekh	146	2445	157.5	1654.3	15	20	16.2	20.6	16	12	17.3	49.1	40	6	43.2	6.2
Дүн Total	902	18046	126.2	335.2	136	65	19.0	8.9	91	32	12.7	17.7	168	27	23.5	3.7

Халдварт өвчний бүтэц:



Гэдэсний халдвар болон цусаар дамжих халдвар

Sum сумын нэр	Гэдэсний халдвар								Цусаар дамжих							
	Цусан суулга Shigellosis				Гепатит А AcutehepatitisA				Гепатит С AcutehepatitisC				Гепатит В Acutehepatitis B			
	Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p		Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p		Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p		Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p	
	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
БД/Bd		1														
БО/Bo																
БУ/Bu																
ГТ/Gt																
МО/Mo																
МН/Mn																
НО/No																
НН/Nn																
СЭ/Se																
ХБ/Khb																
ХХ/Kh-kh																
ХҮKhu																
ЦОТso																
ЦЦ/Ts-ts	11		13													
бусад																
ШБ/Shb	2	3	1.8	2.4												
ӨО/Uo	1	1	1.4	1.3												
ЭХ/Ekh	5	4	5.4	4.1					1		1					
Дүн Total	19	9	2.7	1.2		0		0	1		0.1			0		0

Амьсгалын замын болон зоонозын халдвар:

Sum	Амьсгалын замын халдвар														Зоонозын халдвар					
	Сүрьеэ /Tubercu losis/				Гар хөл амны өвчин				КОВИД-19				Салхин цэцэг / Varicella				хачигт рекетсиоз / tick- borne rickettsioses			
	Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p		Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p		Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p		Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p		Бодит тоо Abs.nu m		10000 хүн амд per10000p	
	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
Сумын нэр																				
БД/Bd		1		4.8						317		1513.8	1		4.7		1	2	4.7	9.5
БО/Bo										272		1485.5	1		5.5					
БУ/Bu										356		1699.3								
ГТ/Gt	4		7.7							556		1052.0	4		7.7					
МО/Mo		1		6.1						181		1109.7		1		6.1	1		5.4	
МН/Mn	1		3.7							644		2383.4	59		221. 2					
НО/No		2		14.5						333		2416.5	2		14.1					
НН/Nn	1		3.9							251		1006.4								
СЭ/Se	1	1	4.9	4.9	1		4.9			174		855.0	1		4.9					
ХБ/Khb	2	2	2.5	2.5						1645		2036.1	19		23.3		1		1.2	
ХХ/Khk h	1		5.0		3		15.1			267		1326.4	3		15.1					
ХҮKhu										250		1590.3	15		94.6					
ЦОТso	2		10.5							407		2085.0								
ЦЦ/Ts- ts		4		4.6	4		4.7			1979		2292.6	17		20.1					
бусад	1	1				1				3268			2							
ШБ/Shb	6		5.3		19	2	16.9	1.6		2899		2403.8	52	2	46.2	1.6	1		0.8	
ӨО/Uo	4	2	5.5	2.7	11		15.1			1541		2092.0	32	1	43.8	1.3				
ЭХ/Ekh	3	2	3.2	2.1	12	3	12.9	3		2362		2430.0	52	1	56.1	1	1		1.1	
Дүн Total	26	16	3.6	2.2	50	6	7.0	0.8		17702		2427.0	260	5	36.4	0.6	5	2	0.7	0.2

ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Эрүүл мэндийн байгууллагууд нь 9700 дуудлагад 332008 км явж үйлчилсэн байгаа нь өнгөрсөн оноос 2042 дуудлагаар цөөрсөн байна. Харин нийт дуудлагын 14,7 % нь алсын дуудлага, 7,1 % нь осол гэмтлийн дуудлага эзэлж байгаа нь өнгөрсөн оноос нэмэгдсэн байна. Түргэн тусламжийн дуудлагад 10 минутаас хойш гарсан дуудлагын эзлэх хувь өнгөрсөн оноос нэмэгдсэн байна. БОЭТ-с алсын 103 дуудлагад явж үйлчилсэн байна.

Байгууллагын нэр	Түргэн тусламжийн дуудлага	Гүйцэтгэсэн алсын дуудлага	Осол гэмтлийн дуудлагад үйлчилсэн	Дуудлагад явсан км	Түргэн тусламжийн дуудлагын гаралт			Түргэн тусламжийн дуудлагад 10 минутаас хойш гарсан хувь	
					10 минут дотор	11-20 минут дотор	21-с дээш	2020 он	2021 он
БД/Bd	180	58	21	6924	174	4	2	11.6	3.3
БО/Bo	151	13	15	11318	137	12	2	9.6	9.3
БУ/Bu	98	76		8316	96	2	0	0.0	2.0
ГТ/Gt	511	131	18	13613	274	189	48	45.4	46.4
МО/Mo	194	77	1	1358	127	50	17	14.2	34.5
МН/Mn	244	96	24	9226	173	57	14	34.3	29.1
НО/No	167	112	1	17981	51	63	53	55.3	69.5
НН/Nn	254	184	14	41553	145	73	36	48.6	42.9
СЭ/Se	103	95	6	20092	103	0	0	0.0	0.0
ХБ/Khb	812	117	39	58377	680	119	12	16.3	16.1
ХХ/Kh-kh	413	205	1	25909	175	187	51	44.9	57.6
ХҮ/Khu	198	105	10	11862	182	15	1	10.9	8.1
ЦО/Tso	269	43	14	8120	146	101	23	31.8	46.1
ЦЦ/Ts-ts	786	60	30	15864	728	31	27	10.0	7.4
БОЭТөв	5060	103	498	79248	2119	1826	1115	40.3	58.1
ШБ	26			172	22	3	1	14.5	15.4
ӨО	42			995	31	10	1	17.1	26.2
ЭХ	158			1080	62	75	21	47.3	60.8
Бусад/э	34	8	1		20	6	8	32.4	41.2
Бүгд	9700	1433	693	332008	5445	2823	1432	32.7	43.9
Эзлэх хувь		14.7	7.1		56.1	29.1	14.7		


ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД

2021 онд шинээр 203 хүн хөгжлийн бэрхшээлтэй болж, 99 шилжиж, 70 хүн нас барсан ба нийт 2083 хөгжлийн бэрхшээлтэй иргэд өрх сумын эмнэлгийн хяналтад байна. Нийт ХБИргэдийн 53,4% нь эрэгтэй, 46,6% нь эмэгтэй, 16.6% нь /346/ 0-20 хүртэлх насны хүүхэд, 48.5% /1012/ нь 20-50 хүртэлх насны, 34.8% /725/ нь 50-с дээш насны хүн байна. Хөгжлийн бэрхшээлтэй 427 хүн буюу 20.4 % нь байнгын асаргаатай байдаг ба 15-с дээш насны иргэдийн 69,4 % нь ажилгүй байна. 45 иргэн протезтэй, 57 иргэн тэргэнцэртэй байна.

Хөгжлийн бэрхшээлийн төрөл:



Хөгжлийн бэрхшээлд хүргэсэн шалтгаан:



АХМАД НАСТНЫ ЭРҮҮЛ МЭНД

